

ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Хууль сахиулах удирдлагын магистрант, хошууч М.Төгөлдөр

Товч агуулга.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа (disaster management) нь өөр хоорондоо уялдаа бүхий гамшгийн өмнө, гамшгийн үе болон гамшгийн дараах гэсэн үе шатуудад хэрэгжих хэд хэдэн үйл ажиллагаа, олон тооны арга хэмжээнээс бүрддэг. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд “гамшгаас хамгаалах үйл ажиллагаа”-г гамшгийн өмнөх үе шатанд урьдчилан сэргийлэх, гамшгийн үед эрэн хайх, аврах, гамшгийн дараах үед хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох гэсэн 3 үе шатанд хамаарах 4 үйл ажиллагаа байхаар тодорхойлсон.

Түлхүүр үг. Системийн арга

Үндсэн хэсэг

Гамшгийн үе шатанд аюулт үзэгдэл, осол тохиолдохын дөнгөж Өмнө, үед болон дөнгөж тохиолдсон даруйд хүний амь нас үрэгдэх, гэмтэж бэртэх, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд хохирол учрахыг хязгаарлахад чиглэсэн арга хэмжээнүүд хамаардаг. Өөрөөр хэлбэл гамшгийн үе шат нь аюулт үзэгдэл, осол нүүрэлсэн цагаас эхлээд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан зарласан онцгой байдлыг цуцлах хүртэл үргэлжилдэг.

Хор уршгийг арилгах ажиллагаанд нэн чухал дэд бүтэц (хаагдсан зам, давааг нээх, харилцаа холбооны болон цахилгааны шугамыг засах, хүнс, цэвэр усаар хангах зэрэг)-ийг богино хугацаанд хэвийн болгох арга хэмжээ хамаарах ба ингэснээр нэмж олон хүн гэмтэж бэртэх, амь насаа алдахыг багасгаж, нийгмийг хэвийн байдалд нь хурдан эргэж оруулах нөхцөл бүрдэнэ.

Дадлага, сургуулилт болон сургалтаар аврах, хор уршгийг арилгах ажиллагааг гардан явуулах бие бүрэлдэхүүний ур чадварыг нэмэгдүүлж, маш сайн гамшгийн үеийн шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулж бэлэн байдлаа хангаж болох ч тухайн гамшгийн аюулын онцлогийг тусгасан олон тооны урьдчилан таамаглаагүй нөхцлүүд бий болж байдаг. Ийм учраас гамшгийн үеийн аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд мэдээлэл ба шуурхай удирдлага, зохицуулалт нь хамгийн чухал байдаг

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт нь:

- Ерөнхий сайдын удирдлагад ажиллах гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын

- Монгол Улсын Шадар сайд чиглүүлж, гамшгаас хамгаалах төрийн бодлого, гамшгаас хамгаалах талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй онцгой байдлын байгууллага,

- Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажлыг шуурхай зохион байгуулах чиг үүрэг бүхий Улсын онцгой комисс

- Бүх шатны ИТХ, Засаг дарга ,
- Аж ахуйн нэгж, байгууллага,
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага ,
- Олон нийт, иргэд гэсэн оролцогч талуудаас бүрдсэн байна.




Зураг 1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

Эх сурвалж: <https://nema.gov.mn/>

Гамшгаас хамгаалах тухай хуулинд “гамшгийн өмнөх үйл ажиллагаа”-нд дараах 7 арга хэмжээг хуульчилжээ. Үүнд:

- Гамшгийн эрсдэлийг үнэлэх;
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах;
- Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах;
- Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх;
- Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах;
- Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх.

Зураг 2



Зураг 3



гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт

- Гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний болон орон нутгийн зөвлөл
- Улсын болон аймаг, нийслэл, сум дүүргийн Онцгой комисс
- Онцгой байдлын байгууллага
- Гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба
- Мэргэжлийн анги
- Сайн дурын хэсэг байгуулах
- МУЗН нэмэлт хүч болон ажиллана.

Орчин үеийн олон улсын харилцааны шинжлэх ухаанд системийн арга нэвтэрсэн нь

Европын улсуудын шашин хоорондын 30 жилийн дайны төгсгөлд байгуулагдсан 1648 оны Вестфалийн энхийн гэрээгээр орчин үеийн олон улсын харилцааны систем үүсч бий болсон бөгөөд энэхүү Вестфалийн гэрээгээр:

- Үндэсний эрх ашгийг дээдлэх зарчим
- Хүчний тэнцвэрийн зарчим

- Үндэсний төрт улсыг хүлээн зөвшөөрөх зарчим
- Төрт улсын бүрэн эрхийн зарчим:
 - Улс гүрний дотоод хэрэгт үл оролцох зарчим
 - Европын улсуудын тэгш эрхийн зарчим
 - Гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх зарчим
 - Олон улсын харилцаанд яриа хэлэлцээр буюу дипломат ажиллагаа болон Олон улсын эрх зүйг хэрэглэх зарчим гэх мэт өнөөгийн ОУХ-ны зарчмуудын үндсэн суурь нь тавигдсан төдийгүй орчин үеийн ОУХ-ны анхдагч систем болох Вестфалийн систем бүрэлдэн тогтжээ.

Системийн анализ гэдэг нь явцуу утгаараа улс төр, цэрэг-стратег, нийгэм-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн нарийн төвөгтэй бүтэц бүхий асуудалд анализ буюу дүн шинжилгээ хийх арга зүйн цогц бөгөөд өргөн утгаараа системийн анализ гэдэг нь аливаа зүйлийг судлах системийн хандлага хэмээн Оросын судлаач А.Д.Богатуров системийн аргыг тодорхойлсон бол ОУХ-г системийн түвшинд судлах хандлага 1950-иад оны дундуур тухайн үеийн улс, төр, олон улсын харилцааны шинжлэх ухаанд ноёрхох байр суурьтай байсан реализмын онолыг шүүмжилж байсан бихевиоризмын онолын сургууль /улс төрийн модернизм/ гарч ирсэнээр тавигдсан билээ.

Систем гэдэг нь бие биетэйгээ харилцан хамаарал бүхий элементүүдийн нэгдэл,

Элементүүд гэдэг нь системийг бүрдүүлэгч энгийн хэсгүүд буюу ерөнхий системийг бүрдүүлж буй дэд системүүд,

Системийн орчин гэдэг нь системийн харьцаж буй болон системд нөлөөлж буй гол хүчин зүйл,

Системийн бүтэц гэдэг нь системийн янз бүрийн түвшинд тусгалаа олж байдаг ээдрээ бүхий хэд хэдэн төлөв байдалтай байдаг. Үүнд дараах төлөвүүд багтана

- а. Систем дэх элементүүдийн харьцаа
- б. Систем дэх элементүүдийг зохион байгуулах чадвар
- в. Элементүүдийн төлөө оршин тогтнож буй системийн шаардлагаас гарч буй хязгаарлалт болон албадлагын үйл ажиллагааны цогц,

Системийн үүрэг гэдэг нь системийн бүтцэд багтаж байгаа элементүүдийн хооронд тогтсон тодорхой шинжийн харилцаа буюу

тогтвортой байдлыг хадгалах зорилгоор системийн орчны өөрчлөлтөд хариу үзүүлж буй үйлдэл хэмээн үзсэн.

Олон улсын харилцааны систем гэдэг нь ОУХ-ны түүхийн тодорхой үед өөрийн гэсэн онцлог бүхий орчинтой олон улсын харилцааны бүтэц тогтож байдаг ба энэхүү түүхэн тодорхой үед янз бүрийн оролцогчдын / гол нь nation state буюу үндэсний улс/ хоорондын тогтсон бие биедээ харилцан нөлөөлөгч төрөл бүрийн харилцааны хэлхээ холбоос бүхий нэгдмэл цогц бөгөөд олон улсын харилцааны системийн зорилго нь тухайн системийн тогтвортой байдлыг хадгалахад оршдог.

Дүгнэлт

Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөөг сайтар судалж, шааардлагатай хамтын ажиллагааг сайжруулах баримт бичгийг тодорхойлж, тэдгээр баримт бичгийн боловсруулалтыг дэмжих хэрэгтэй байна.

Монгол улс Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд батлуулж Дэлхий нийтийн гамшгаас хамгаалах менежментийн чиг хандлагад хөл нийлүүлэн алхаж эрхзүйн үндэсийг бүрдүүлж өгсөн. Тус хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь гамшгаас хамгаалах менежментээс гамшгийн эрсдэлийг бууруулах менежментэд шилжиж байна гэж ойлгож байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Гамшгаас хамгаалах тухай хууль УБ., 2017 он.
2. Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо: хөгжил, хандлага, 2013
3. Гамшгаас хамгаалах менежментийн үндэс. 2017
4. www.legalinfo.mn
5. www.nema.gov.mn